



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/206

Улаанбаатар хот

Үлгэрчилсэн загвар, аргачлал
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 5.1.4; 28.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сургуулийн өмнөх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол олгох "Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө"-ний үлгэрчилсэн загварыг нэгдүгээр, "Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах аргачлал"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалын хавсралтаар баталсан үлгэрчилсэн загвар, аргачлалын хэрэгжилтийг удирдлагаар хангаж ажиллахыг Сургуулийн өмнөх боловсролын хэлтэс /Ж.Мягмар/, цэцэрлэгийн багш, ажилтан нарт арга зүйн дэмжлэг үзүүлэн, зөвлөн туслах ажлыг үе шаттай зохион байгуулахыг Боловсролын ерөнхий газар /Т.Ням-Очир/ нарт тус тус үүрэг болгосугай.

3. Сургуулийн өмнөх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролын үйлчилгээнд тэгш хамруулах, тэдний ялгаатай хэрэгцээнд нийцсэн сургалтын орчин бүрдүүлэх, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, багш, эцэг эх, асран хамгаалагчдыг чадавхжуулах сургалтыг үе шаттай зохион байгуулахыг өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэгийн эрхлэгч нарт даалгасугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Л.Цэдэвсүрэн/-д даалгасугай.


САЙД



Д.ЭНХ-АМГАЛАН



Боловсрол, шинжлэх ухааны сайдын
 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн
 *1/дог. дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ГАНЦААРЧИЛСАН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Боловсруулсан огноо :

Хүүхдийн овог нэр		Төрсөн огноо	Он Сар Өдөр (... нас ... сар)
Цэцэрлэг/ бүлэг		Бүлгийн багш	
Хүүхэд болон эцэг эх, асран хамгаалагчийн хүсэл, зорилго		Бүлгийн багшийн зорилго	
Зорилго			

Хөгжлийн чиглэл	Хугацаа	Хүүхдийн бодит байдал	Дэвшүүлсэн зорилт	Багшийн дэмжлэг, арга зүй	Хүүхдийн хөгжилд гарсан өөрчлөлт, тэмдэглэл
Нийгэмшихүй	Эхний хагас				
	Сүүлийн хагас				
Бие бялдар, хөдөлгөөн	Эхний хагас				
	Сүүлийн хагас				
Хэл яриа	Эхний хагас				
	Сүүлийн хагас				
Байгаль, нийгмийн орчин	Эхний хагас				
	Сүүлийн хагас				
Математикийн энгийн төсөөлөл	Эхний хагас				
	Сүүлийн хагас				
Хөгжим	Эхний хагас				
	Сүүлийн хагас				
Дүрслэх урлаг	Эхний хагас				
	Сүүлийн хагас				

Дүгнэлт	(Огноо :)
---------	------------

Тэмдэглэл хөтөлсөн Багшийн нэр, гарын үсэг:..... /..... /

Огноо ____ _

Танилцсан эцэг эх (асран хамгаалагч)-ийн нэр, гарын үсэг:..... /..... /

Огноо ____ _



ГАНЦААРЧИЛСАН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ АРГАЧЛАЛ

Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө /цаашид "ГСТ" гэх/ нь сургуулийн өмнөх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн онцлог, хэрэгцээ, төлөв байдлыг үнэлэн тогтоож, урт, дунд, богино хугацааны зорилго, зорилтууд, сургалт, үйл ажиллагааны агуулга, багшийн дэмжлэг, арга зүй төлөвлөлт, хэрэгжилтэд үнэлгээ хийх үйл ажиллагааг нэгтгэн хөтлөх баримт бичиг юм.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч болон багшийн хүсэлтэд үндэслэн хүүхдийн хөгжлийн онцлог, хэрэгцээ шаардлагыг харилцан тохиролцсоны үндсэн дээр ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ.

Цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээ, эрүүл мэндийн бодит байдалд нийцүүлэн хөгжих, сурах эрхийг хангах орон тооны бус 7-9 хүний бүрэлдэхүүнтэй "Дэмжлэгийн баг" байгуулж ажиллана.¹

Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө нь доор дурдсан зорилтыг хангахад чиглэгдэнэ.

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүрийн хөгжлийн онцлог, хэрэгцээ, шаардлагыг зөв тодорхойлж, тэдэнд тохирсон тусгай хэрэгцээт боловсролын үйлчилгээг үзүүлэх;
2. Хүүхдийн хөгжлийн бодит байдалд тулгуурлан цэцэрлэгийн болон гэрийн бүлийн орчинд тухайн хүүхэдтэй ажиллах сургалт, үйл ажиллагааны агуулга, багшийн болон мэргэжилтний арга зүй, дэмжлэгийн тогтолцоог тодорхойлж, хэрэглэх;
3. Хүүхдийн хөгжлийн ахицыг илрүүлэх, тэдний ахуй амьдрал, суралцах үйлд тулгарч буй бэрхшээлийг арилгах;

Цэцэрлэгийн багш ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулахдаа дараах зарчмыг баримтална.

- Хүүхдийн хөгжлийн онцлог, хэрэгцээ, шаардлагад нийцсэн, түүний хөгжлийг дэмжсэн байх;
- Зорилт үнэлэгдэхүйц, биелэгдэхүйц байх;
- Хувийн мэдээллийн нууцлалыг чанд хадгалах;
- Хүүхдэд дарамт шахалт үзүүлэхгүй байх;
- Оролцогч талууд харилцан хүлээн зөвшөөрсөн байх;
- Тогтоосон хугацаанд шинэчлэн боловсруулж байх;

Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах үе шат, шийдвэрлэх арга зам:

- ГСТ-өөр суралцах хүсэлтийг эцэг, эх, асран хамгаалагч, эсвэл бүлгийн багш гаргаж болно.
- Хүсэлт гаргасан тохиолдолд бүлгийн багш эцэг, эх, асран хамгаалагчийн уулзалтыг зохион байгуулна.
- Эцэг, эх, асран хамгаалагч нь хүүхдийн ГСТ-ний агуулгад тусгах санал,

¹ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд цогц дэмжлэг үзүүлэх аргачлал, маягт шинэчлэн батлах тухай" 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/220, А/475, А/812 тушаал

хүсэлтээ илэрхийлнэ.

- Сонирхогч талууд харилцан зөвшилцсөний үндсэн дээр ГСТ-өөр суралцах тохиолдолд холбогдох баримт бичгийг бүрдүүлэн цэцэрлэгийн дэмжлэгийн багт хандана.
- Цэцэрлэгийн дэмжлэгийн баг хуралдаж, эцсийн шийдвэрийг гаргана.
- Цэцэрлэгийн дэмжлэгийн багт цэцэрлэгийн арга зүйч, багш, эмч, эцэг эх, асран хамгаалагчийн төлөөлөл, тусгай хэрэгцээт боловсролын багш, баг, хорооны нийгмийн ажилтан, сэтгэл зүйч зэрэг хүмүүсийн төлөөлөл орно.

ГАНЦААРЧИЛСАН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БҮТЭЦ

Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах, түүний үр дүнг дүгнэхийн тулд төлөвлөгөөнд тусгах үндсэн зүйл (зорилго, хүүхдийн бодит байдал, зорилт ямар байх талаар, багшийн дэмжлэг, арга зүйн үндсэн зарчим)-ийн талаар цэцэрлэгийн дэмжлэгийн баг болон бүлгийн багш хамтран хэлэлцэнэ.

Сургуулийн өмнөх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг дараах загвар бүтэцтэйгээр боловсруулна.

1. Хүүхдийн бодит байдлын судалгаа
2. Урт, дунд, богино хугацааны зорилго, зорилт, дэмжлэгийн орчин
3. Хөгжлийн чиглэл тус бүрээр багшийн дэмжлэг, арга зүй,
4. Хүүхдийн хөгжилд гарсан ахиц, өөрчлөлтийн тэмдэглэл

Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах бэлтгэл ажил:
Хүүхдийн бодит байдлыг судална.

1. Цэцэрлэгт хамрагдахын өмнөх ярилцлага

Цэцэрлэгт хамрагдахаас өмнө эцэг, эх, асран хамгаалагчтай ярилцлага хийж, хүүхдийн өсөлт хөгжлийн түүх болон амьдралын дадал хэвшлийн талаар мэдээлэл цуглуулна. Туршилтаар цэцэрлэгт хамрагдах боломж, нөхцөлийг бүрдүүлэн, эцэг, эх, асран хамгаалагчийн дэмжлэгтэйгээр цэцэрлэг дээр эрхлэгч, арга зүйч, бүлгийн багш нар тухайн хүүхдийн үйлдлийг ажиглана. Ярилцлагын үеэр хавсралт дахь "Ярилцлагын хуудас"-ыг ашиглан мэдээлэл цуглуулж, тухайн хүүхдийн хийж чаддаг зүйлээс гадна чаддаггүй болон дуртай зүйлийн талаар ойлголттой болно.

2. Цэцэрлэгт хамрагдсаны дараах бодит байдлын үнэлгээ

Цэцэрлэгт хамрагдсаны дараа бүлгийн багш тухайн хүүхэд цэцэрлэгийн орчинд хэрхэн дасан зохицож байгаа талаар ажиглаж, тэмдэглэл хөтөлж, бодит байдлыг үнэлж, эцэг эх, асран хамгаалагчдад танилцуулж, хамтдаа дүгнэнэ. "Дэвшүүлсэн зорилт"-оо тодорхойлохын тулд хүүхдэд тулгамдаж буй асуудлыг тодорхой болгосон байна. Асуудлыг шийдэх "Багшийн дэмжлэг, арга зүй"-г бичихийн тулд хүүхдийн хөгжлийн түвшнийг үнэлсэн байх шаардлагатай.

3. Өдөр тутмын тэмдэглэл, үнэлгээ

Дээрх ярилцлага, бодит байдлын үнэлгээний дагуу тухайн хүүхдэд тулгамдаж буй асуудлаа тодорхойлон, зорилтоо дэвшүүлж чадвал, ГСТ-г бичиж эхэлнэ. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй анх удаа ажиллаж байгаа, ГСТ-г анх удаа хөтлөх гэж байгаа багш нар хавсралт "Өдөр тутамдаа хөтлөх загвар"-ыг бөглөснөөр тухайн хүүхдийн бодит байдал, өөрийн үзүүлж болох дэмжлэг, тохирох орчин нь тодорхой болж ирдэг тул үндсэн загварыг хөтлөхөөс өмнө дасгал болгон хөтөлж үзнэ.

Үнэлгээ: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн үнэлгээг БСШУС-ын сайдын (хуучнаар) 2020 оны А/280 дугаар тушаалаар баталсан "Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн хөгжил болон сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх журам"-ын 1.7 -д "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг

тэдний ялгаатай байдлыг харгалзан явцын үнэлгээг хийнэ". Мөн тус журмын 2.1.1-д "Явцын үнэлгээ" гэж хүүхдийн хөгжих үйл явцыг дэмжих зорилгоор сургалт, үйл ажиллагааны явцад багш өдөр тутам хийх үнэлгээг ойлгоно" гэж заасан.

Явцын үнэлгээг сургалт, үйл ажиллагааны явцад хүүхэд бүрийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн ажиглалт, ярилцлага, хувийн хавтас бүрдүүлэх зэрэг арга хэлбэрээр хийж, ганцаарчилсан төлөвлөгөөний дагуу хүүхдийн хөгжилд гарч буй ахицаар хэмжинэ.

Цэцэрлэг нь бүлгийн багшийн боловсруулсан төлөвлөгөөг Дэмжлэгийн багийн хурлаар тогтмол хэлэлцэж, зөвлөлдөн мэдээллээ нэгтгэнэ.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын
2022 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
... дугаар тушвалын нэгдүгээр хавсралт

ГАНЦААРЧИЛСАН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Боловсруулсан огноо : 1

Хүүхдийн овог нэр		Төрсөн огноо	Он	Сар	Өдөр (... нас ... сар)
Цэцэрлэг/ бүлэг		Бүлгийн багш			
Хүүхэд болон эцэг эх, асран хамгаалагчийн хусал, зорилго	2	Бүлгийн багшийн зорилго			3
Зорилго	4				
Хөгжлийн чиглэл 5	Хугацаа 6	Хүүхдийн бодит байдал 7	Дэвшүүлсэн зорилт 8	Багшийн дэмжлэг, арга зүй 9	Хүүхдийн хөгжилд гарсан өөрчлөлт, тэмдэглэл 10
Нийгэмшихүй	Эхний хагас				
	Сүүлийн хагас				
Бие бялдар, хөдөлгөөн	Эхний хагас				
	Сүүлийн хагас				
Хэл яриа	Эхний хагас				
	Сүүлийн хагас				
Байгаль, нийгмийн орчин	Эхний хагас				
	Сүүлийн хагас				
Математикийн энгийн төсөөлөл	Эхний хагас				
	Сүүлийн хагас				
Хөгжим	Эхний хагас				
	Сүүлийн хагас				
Дүрслэх урлаг	Эхний хагас				
	Сүүлийн хагас				
Дүгнэлт 11	(Огноо :)				

Тэмдэглэл хөтөлсөн Багшийн нэр, гарын үсэг:

Огноо ____

Танилцсан эцэг эх (асран хамгаалагч)-ийн нэр, гарын үсэг:

Огноо ____

ГАНЦААРЧИЛСАН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ БОЛОВСРУУЛАХ АЛХАМ

1. “Боловсруулсан огноо”

Цэцэрлэгт элссэн өдрөөс эхлэн боловсруулна.

2. “Хүүхэд болон эцэг, эх, асран хамгаалагчийн хүсэл, зорилго”

Хүүхэд болон эцэг, эх, асран хамгаалагчийн хүсэл, зорилгыг мэдсэний үндсэн дээр тодорхой бичнэ.

- Хүүхэд өөрийнхөө хүслээ илэрхийлэх чадвартай тохиолдолд хүүхэдтэй харилцан ярилцан бичих. Боломжгүй тохиолдолд эцэг эх, асран хамгаалагч хүүхэдтэйгээ хамтран хүсэл, зорилгоо илэрхийлж бичих.

3. “Бүлгийн багшийн зорилго”

Өдөр тутмын үйл ажиллагааны явцад ажиглагдсан, ажиглалтын явцад илэрсэн тулгуурлан хүүхдээс хүсэх зүйлээ тодорхой бичих. Жишээ нь:

- “.....-г болиулах юм сан” зэрэг сөрөг талаас илэрхийлэхгүй байхыг хичээх. Жишээ нь: “ангидаа битгий гүйгээсэй” ⇒ “анхаарлаа төвлөрүүлж, сургалт, үйл ажиллагаанд арай удаан оролцоосой” гэх мэт.

4. “Зорилго”

Хүүхэд болон эцэг эх, асран хамгаалагч, багшийн зорилгод үндэслэн хүүхдийн ирээдүйн дүр зураг, хийж сурах зүйлийг тодорхой бичих.

- 1 жилийн хугацаанд хүүхдийн хүрч болох үр дүнг багш бичнэ.
- Дэмжлэгийн баг болон эцэг, эх, асран хамгаалагчийн саналыг сонсох.
- Хэт өндөр зорилго дэвшүүлэхгүй байх.

5. “Хөгжлийн чиглэл”

Тухайн хүүхдийн ялгаатай хэрэгцээнд тохируулан хөгжлийн чиглэлийг сонгох (хөгжлийн чиглэл бүрээр зорилт дэвшүүлэхгүй байж болно). Жишээлбэл, багш эхлээд “Нийгэмшихүй” чиглэлийн зөвхөн “өөртөө үйлчлэх чадвар”-ыг сонгон авч, агуулгадаа тусгах, сургалт, үйл ажиллагааны явцын дундаас нь хөгжлийн чиглэлийн төрлийг нэмэх, шаардлагагүй тохиолдолд хасаж болно.

Хөгжлийн чиглэл	Хөгжлийн чиглэлийн жишээ
Нийгэмшихүй	“Өөрийгөө мэдрэх, илэрхийлэх”, “Өөртөө үйлчлэх, оролцоотой байх”, “Сэтгэлийн хөдөлгөөнөө зохистой илэрхийлэх”, “Асуудлыг өөрийн хэмжээнд шийдвэрлэх”, “Бусдыг мэдэрч ойлгох”, “Насанд хүрэгчидтэй харилцах”, “Үеийн хүүхдүүдтэй харилцах”, “Бусад хүүхэд (өөрөөсөө насаар ах, дүү)-тэй харилцах”, “Орчны өөрчлөлтөд дасах”, “Хүмүүсийн хоорондох ялгаатай байдлыг ойлгох, хүндэтгэлтэй хандах”, “Оролдлоготой, санаачилгатай, тууштай байх”, “Дүрэм журам, зааврыг ойлгох мөрдөх” зэрэг
Хөдөлгөөн, эрүүл мэнд	“Алхах, гүйх”, “Үсрэх, харайх”, “Мөлхөх, авирах”, “Шидэх, дамжуулах, барих”, “Биеийн хөдөлгөөнөө хянах, зохицуулах”, “Хөдөлгөөнийг гүйцэтгэхдээ биеийн тэнцвэрийг хадгалан алхах”, “Гар хурууны хөдөлгөөнөө зохицуулах”, “Хувийн ариун цэврийг сахих”, “Гэмтэхээс болгоомжлох, өвчлөхөөс сэргийлэх” зэрэг
Хэл яриа	“Орчны болон хэлний авиаг ялгаж сонсох”, “Үгийн утгыг ойлгох, хэрэглэх”, “Санаа бодлоо илэрхийлэн ярих”, “Уншиж, ярьж өгсөн эхийг ярих”, “Зураг, тэмдэг тэмдэглэгээний утгыг хэлэх”, “Янз бүрийн зураас (шулуун, долгион, нуман...) зурах” зэрэг
Байгаль, нийгмийн орчин	“Орчны юмсыг сонирхох, таних, нэрлэх”, “Ургамал, амьтныг ажиглах, таньж мэдэх, арчлах”, “Улирал, цаг агаарын өөрчлөлтийг сонирхох, ялган таних”, “Ойр орчныхоо хүмүүсийн онцлогийг таньж мэдэх” зэрэг
Математикийн энгийн төсөөлөл	“Тоолох, тоо бодох”, “Хэмжих, хэмжээг ялгах”, “Хэлбэр дүрс, өнгийг тодорхойлох”, “Орон зайг баримжаалах”, “Цаг хугацаа заасан үг хэрэглэх” зэрэг
Хөгжим, дүрслэх урлаг	“Хөгжмийн аялгууг ялгаж сонсох, мэдрэмжээ илэрхийлэх”, “Дуулах”, “Хөгжимдөх”, Хөгжмийн аялгуу, хэмнэлд тохируулан бүжиглэх,

	жүжиглэх", "Хүрээлэн буй орчноос ажигласан зүйл, төсөөллөө зурж дүрслэх", "Шавраар эд зүйлс, хүн, амьтныг дүрсэлж бүтээх", "Хүрээлэн буй орчноос ажигласан зүйл, төсөөллөө наах", "Барьж байгуулах, зохион бүтээх" зэрэг
--	--

Эх үүсвэр: "Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөр, хэрэгжүүлэх зөвлөмж" (2019)

6. "Хугацаа"

Хүүхдийг цэцэрлэгт элсэн орсон хугацаанаас хамааран эхний болон сүүлийн хагасыг тогтооно. Онцлоход, хүүхдийн элссэн үе болон хөгжлийн чиглэлийн дагуу шаардлагатай гэж үзвэл хугацааг нэмж хасах байдлаар тохируулж болно. Боловсруулж буй багш хүүхдийн хөгжлийн онцлог, хэрэгцээнд нийцүүлэн шийдэх.

7. "Хүүхдийн бодит байдал"

Цэцэрлэгийн орчинд хэрхэн дасан зохицож байгаа талаарх багшийн ажиглалтын тэмдэглэл, эцэг, эх, асран хамгаалагчаас авсан асуумж дээр үндэслэж, сонгон хөтөлж буй "хөгжлийн чиглэл" тус бүр дээр хүүхдийн хөгжлийн түвшин (нөхцөл байдал)-г тэмдэглэх.

8. "Дэвшүүлсэн зорилт"

"Хүүхдийн бодит байдал"-ын дараагийн түвшин болох "Ямар түвшинд хүрэх, эсвэл юу хийж сурсан байх" талаар тодорхой бичнэ.

- Алхам алхмаар задлан, биелэгдэх боломжтой зорилт дэвшүүлэх.
- "..... -г болиулах юм сан" зэрэг сөрөг талаас илэрхийлэхгүйг хичээх.

9. "Багшийн дэмжлэг, арга зүй"

"Зорилт"-д хүрэхийн тулд багш хүүхдийн мэдлэг, чадварын тухайн түвшнийг яаж ахиулах ялгаатай арга зүй, тохирох хэрэглэгдэхүүн, хэрхэн туслах, ямар чадварт сургах, ямар дасгал, тоглоомоор тоглуулахаа төлөвлөнө. Дэмжлэг үзүүлэх арга зүйг дэмжлэгийн орчинтой холбон Хэн? Хэзээ?, Яаж? Ямар дэмжлэг үзүүлж, зааж сургах талаар тодорхой, ойлгомжтой бичнэ.

- Хэрэгжүүлэх явцад арга зүйг өөрчлөх шаардлага гарч ирдэг. Дэмжлэгийн баг болон мэргэжилтнүүдийн саналыг тусган, нэмж болно.
- Бүлгийн ажлын төлөвлөгөөтэй уялдуулан дэмжлэг, арга зүйг судлах нь чухал.

10. "Хүүхдийн хөгжилд гарсан өөрчлөлт, тэмдэглэл"

Өдөр тутмын сургалт, үйл ажиллагааны явцад хүүхдийн хөгжлийг дэмжих арга зүйг хэрэгжүүлснээр гарсан өөрчлөлтийг тодорхой бичих.

- Хүүхдийн хөгжлийн ахицыг голлон бичих, ахиц гараагүй тохиолдолд хүүхдэд илэрсэн өөрчлөлтийг бичнэ.

11. "Дүгнэлт"

Хичээлийн жилийн эцэст зорилгодоо хүрэхийн тулд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, зорилгодоо хүрсэн байдлыг бичих.

- "Зорилгодоо хүрсэн / хүрээгүй"-ээс гадна хүүхдийн ахиц болон үзүүлсэн дэмжлэг, арга зүй, дэвшүүлсэн зорилтуудаа эргэн харж, дараагийн зорилт, дэмжлэгтэй уялдуулах нь чухал.
- Цэцэрлэгийн дэмжлэгийн багийн хурлаар хэлэлцсэн дүгнэлт, тэмдэглэл дээр тулгуурлан бичвэл зохино.